

МОНГОЛ УЛСЫН ГАДААДЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН БАЙДАЛ БА ШИНГЭЭХ ЧАДАВХИЙН ТУХАЙ

(Дипломат албаны 100 жил, Гадаадын хөрөнгө
оруулалтын газрын 15 жилийн ойд зориулав)

*Б.Ганзориг**

*Д.Начин***

Өмнөтгөл

Монгол Улс эрчимтэй хөгжлийн гарааны эхэнд тулж ирээд байгаа энэ үед манай орны хөгжилд дорвитой нөлөө үзүүлж буй гадаадын хөрөнгө оруулалтын байдалд үнэлэлт дүгнэлт өгч, цаашдын чиг хандлагыг нь тодорхойлох шаардлагатай болоод байна. Уул уурхайн олборлолт хийх, боловсруулах үйлдвэрлэл бий болгох, дэд бүтцийн томоохон бүтээн байгуулалт зэрэгт ихээхэн хэмжээний хөрөнгө оруулалт, түүний дотор гадаадын шууд хөрөнгө оруулалт шаардлагатай. Гадаадын хөрөнгө оруулалтыг татах орчин, боломж тодорхой хэмжээнд бүрдсэн бөгөөд гагцхүү түүнийг илүү үр дүнтэй, үр өгөөжийг ард иргэдэд хүртээмжтэй ашиглах асуудал шийдлээ хүлээж байна. Үүнтэй холбогдуулж юуны өмнө манай орны гадаадын хөрөнгө оруулалт шингээх чадавхийн асуудлыг хөндөх учиртай.

Судлаачдын үзэж байгаагаар гадаадын хөрөнгө оруулалт шингээх чадавхи гэдэгт тухайн орны аж ахуйн нэгж, компаниудын гадаадын хөрөнгө оруулалтыг шингээх чадавхи, хүний нөөцийн чадавхи, санхүүгийн системийн чадавхи, гадаадын хөрөнгө оруулалтын эрх зүй, хэрэгжилтийг хангах орчин нөхцөл зэргийг бүхэлд нь ойлгох бөгөөд эдгээр нь хэдий чинээ сайн хөгжсөн байна, тэр хэмжээгээр гадаадын хөрөнгө оруулалтын үр өгөөж өндөр байдаг аж.

Гадаадын хөрөнгө оруулалтын үр өгөөжийг эдийн засгийн өсөлт, төсөвт оруулж буй хувь нэмэр, экспортын хэмжээ, экспортын бүтээгдэхүүний нэр төрөл нэмэгдсэн байдал, цаашилбал, өндөр технологиор бүтээгдсэн барааны нийт экспортод эзлэх хувь хэмжээ, ард иргэдийн хүртээмж зэргээр үнэлж болох юм. Олон улсын валютын сангаас уул уурхайн салбарын давамгайлсан хөгжил нь эдийн засгийн бүтцэд өөрчлөлт оруулж, уул уурхайн бүтээгдэхүүний их хэмжээний экспортын орлогоос улбаалан үндэсний мөнгөн тэмдэгтийн ханш чангарах, инфляци өсөх зэрэг эрсдэл гарч болохыг анхааруулж байгаа билээ. Энэ өгүүлэлд Монгол дахь гадаадын хөрөнгө оруулалтын байдал, цаашдын төлөв, гадаадын хөрөнгө оруулалтын үр ашгийг нэмэгдүүлэх, түүний хувиарлалтын зэрэг асуудлыг хөндөх юм.

* Б.Ганзориг - Гадаадын хөрөнгө оруулалтын газрын дарга, доктор (Ph.D)

** Д.Начин - Мөн газрын хэлтсийн дарга

I. Гадаадын хөрөнгө оруулалтын байдал

Монголд 1990 оноос эхлэн худалдаа, нийтийн хоолны зэрэг хөрөнгө оруулалт бага шаардах салбарт гадаадын хөрөнгө оруулалт багахан хэмжээгээр орж тухайн үед эдгээр салбарын хөрөнгө оруулалт нийт хөрөнгө оруулалтын нилээд хувийг эзэлж байсан бол сүүлийн жилүүдэд уул уурхайн салбарын хөрөнгө оруулалт нэмэгдэж, улмаар нийт хөрөнгө оруулалтын 60 гаруй (ГХОГ, 2010) хувийг бүрдүүлэх болсон бөгөөд цаашид ч өсөх хандлагатай байна. Гэхдээ өндөр хүчин чадалтай техник, тоног төхөөрөмж ашиглан эрдэс баялаг их хэмжээгээр олзворлох, энэ салбарын бүтээгдэхүүний экспорт огцом нэмэгдэх хандлагатай байна. Монгол Улсын нийт экспортын орлогын 80 орчим хувийг уул уурхайн, гэхдээ бараг ихэнхийг нь анхан шатны боловсруулалттай бүтээгдэхүүн бүрдүүлж байна.

Боловсруулалт хийсэн, ялангуяа технологийн өндөр түвшний боловсруулалт хийсэн бүтээгдэхүүний хувь хэмжээ ҮХЦХ-ноос хийсэн судалгаагаар 3%-аас хэтрэхгүй байгаа аж. Электролизийн аргаар гарган авсан катодын зэс нийт экспортын дөнгөж 0.62% (ГЕГ, 2010) эзэлж байгаа нь уул уурхайн, үүний дотор анхан шатны боловсруулалт хийгдсэн бүтээгдэхүүн экспортод давамгайлж байгааг харуулж байна. Түүхий элдэд боловсруулалт хийж нэмүү өртөг бий болгох нь хавьгүй илүү үр ашигтай гэдэг нь ойлгомжтой боловч манай орны гадаадын хөрөнгө оруулалт шингээх чадавхиас шалтгаалан тэгэхгүй байна. Түүнчлэн Монгол Улсын гарал үүсэлтэй бүтээгдэхүүнийг хөгжингүй зарим орнуудад экспортлоход Хөнгөлөлтийн ерөнхий системийн дагуу тарифын хөнгөлөлт эдлэх боломжтой (АНУ-д 3000, Европын холбоонд 7200, Японд 3000 нэр төрлийн бүтээгдэхүүн) боловч түүнийхээ дөнгөж 0,1%-ийг ашигладаг гэсэн тооцоог МҮХАҮТ-аас гаргасан байна. Манай бизнес эрхлэгчид 2009 онд Европын холбооны зах зээлд 5155100 ам.долларын (нийт 1902.1 сая ам.долларын экспортын дөнгөж 0.27%) ноолууран цамц, хөнжил, нөмрөг, ороолт зэргийн бүтээгдэхүүн экспортлосон (татваргүй) нь 494890 ам.доллартай тэнцэх хөнгөлөлтийг GSP+ буюу шинэчилсэн ХЕС-ийн дагуу эдэлсэн байна (МҮХАТ, 2010).

Монгол Улсын Засгийн газрын идэвхитэй ажиллагааны үр дүнд гадаадын хөрөнгө оруулалт жилээс жилд өсөн нэмэгдэж, 2010 оны эцсийн байдлаар өссөн дүнгээр 4,84 тэрбум ам.долларт хүрэв. 2008-2010 онд бүртгэгдсэн хөрөнгө оруулалт 1990 оноос хойш бүртгэгдсэн нийт хөрөнгө оруулалтын 52,4 хувьтай тэнцэж, 1990-2004 онуудад бүртгэгдэж байсан хөрөнгө оруулалтын жилийн дундаж хэмжээнээс даруй 13-20 дахин нэмэгдсэн байна (ГХОГ, 2010). 2008-2010 онд гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжүүдээс улсын төсөвт 650 гаруй тэрбум төгрөгийг орлогын албан татвар (ТЕГ, 2010), 154,6 тэрбум төгрөгийг нийгмийн даатгалын шимтгэлд тус тус төлсөн бөгөөд

мөн хугацаанд давхардсан тоогоор нийт 118,1 мянган хүнийг ажлын байраар ханган (НДЕГ, 2010) ажиллуулсан байна.

Энэ бүгдээс дүгнэхэд гадаадын хөрөнгө оруулалт нь улс орны нийгэм эдийн засгийн хөгжилд бодит хувь нэмэр оруулж байгаа боловч цаашид гадаадын хөрөнгө оруулалтын үр ашгийг дээшлүүлэхийн тулд гадаадын хөрөнгө оруулалт шингээх чадавхийг дээшлүүлэх асуудалд анхаарах шаардлагатай нь харагдаж байна.

II. Гадаадын хөрөнгө оруулалтын бодлогын хэрэгжилт ба эрх зүйн орчин

Гадаадын хөрөнгө оруулалтын тухай Монгол Улсын хуульд заасны дагуу Гадаадын хөрөнгө оруулалтын газар нь гадаадын хөрөнгө оруулалтын талаархи бодлого, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, гадаадын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх нөхцөл бололцоог судлах, гадаад сурталчилгааны ажлыг зохион байгуулах, төслийн тендерт гадаадын хөрөнгө оруулагчдыг татан оролцуулах, гадаадын хөрөнгө оруулагчдад “нэг цэг”-ийн иж бүрэн үйлчилгээ үзүүлэх зэрэг чиг үүрэгтэй. Түүнчлэн Монгол Улсын гадаадын хөрөнгө оруулалтыг хамгаалах талаар нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенц (“Хөрөнгө оруулалтын талаар үүссэн маргааныг шийдвэрлэх тухай” Вашингтоны конвенц, “Хөрөнгө оруулалтын даатгалын олон талт агентлаг байгуулах тухай” Сөүлийн конвенци зэрэг) болон хоёр талын хэлэлцээрүүд (Хөрөнгө оруулалтыг хөхиүлэн дэмжих хоёр талын хэлэлцээрийг 42 оронтой байгуулсан)-ийг хэрэгжүүлэх үүрэг хүлээдэг билээ.

Гадаадын хөрөнгө оруулалт нь одоогийн хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хуульд заасан (чөлөөтэй хөрвөх валют, хөдлөх болон үл хөдлөх хөрөнгө, тэдгээртэй холбогдсон эд хөрөнгийн эрх) төрлөөр хийгдэж, гол төлөв гадаадын дагнасан болон Монголын хөрөнгө оруулагчтай хамтарсан аж ахуйн нэгж байгуулах хэлбэрээр хэрэгжиж, оюуны болон аж үйлдвэрийн өмчийн хэлбэрээр бараг хийгдэхгүй байна. Монгол Улсын хуулийн этгээд болох аж ахуйн нэгжүүдэд гэрээний дагуу байгалийн баялаг ашиглах, боловсруулах эрх олж авах боломж нээлттэй болдог. Концессийн тухай хууль батлагдан гарсанаар концессийн гэрээ (Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан) байгуулах боломж бүрдэв. Хэдийгээр Гадаадын хөрөнгө оруулалтын хууль (6 дугаар зүйл)-д маркетинг, менежментийн гэрээ байгуулах, санхүүгийн түрээс (лизинг)-ийн болон франчайзийн хэлбэрийн хөрөнгө оруулалт хийх боломж нээлттэй байдаг боловч ийм хэлбэрээр хөрөнгө оруулалт хийх нь харьцангуй цөөн, тэгээд ч тус газарт бүртгэгдэхгүй байна. Түүнчлэн тус хуулийн 14 дүгээр зүйлийн 2.2-д заасан Гадаадын хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн төрийн

захиргааны байгууллагын ... төслийн тендерт гадаадын хөрөнгө оруулагчдыг татан оролцуулах гэсэн бүрэн эрхийн хэрэгжилт учир дутагдалтай байна.

Өнөөдөр Монгол Улсын гадаадын хөрөнгө оруулалтын орчин 1993 онд Гадаадын хөрөнгө оруулалтын хууль батлагдаж байх үеийнхээс өөр болж шинэчлэгдсэн, хөрөнгө оруулагчид гадаад, дотоодын гэлтгүй ижил нөхцөлд бизнес эрхлэх боломжтой болсон, хөрөнгө оруулалтын чанарыг дээшлүүлэх зорилгоор тус хуульд нэмэлт өөрчлөлт оруулж хөрөнгө оруулалтын босгыг 10 мянган ам.доллараас 100 мянган ам.доллар болгож өндөрсгөв.

Гадаадын хөрөнгө оруулагчид Монгол Улсад гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих орчин үндсэндээ бүрдсэн, үүнээс уул уурхайн салбарынх нь илүү тодорхой, боломжийн гэж үзэж байгаа бөгөөд үүнийг Оюу Толгойн хөрөнгө оруулалтын гэрээнд гарын үсэг зурснаар гадаадын хөрөнгө оруулалтын хэмжээ огцом өссөн гэж үздэг.

Гадаадын хөрөнгө оруулалтын талаар 1990 оноос одоог хүртэл баримталж ирсэн бодлогыг “Төрийн оролцоо багатай, нээлттэй бодлого” хэмээн тодорхойлж болох бөгөөд Монгол Улсын цаашдын хөгжил нь гадаадын шууд хөрөнгө оруулалт, гадаад худалдаанд тулгуурлан хөгжих тул цаашид “Төрийн зохистой оролцоо бүхий нээлттэй бодлого” баримтлах нь зүйтэй хэмээн үзэж байна (Ганзориг Б, 2008). Чингэхдээ тэргүүлэх салбарт урамшуулал, хяналтыг тэнцвэртэй байлгах, төрийн оролцоог гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд саад бэрхшээл учруулахгүй түвшинд байлгах, гадаадын хөрөнгө оруулалтын улс орны нийгэм эдийн засагт үзүүлж буй нөлөөллийг төр хянаж, зохицуулж чаддаг байх шаардлагатай. Түүнчлэн, өрсөлдөх чадвар сул, хөгжлийн түвшин доогуур байгаа зарим салбарт гадаадын хөрөнгө оруулалтыг уриалан татдаг, өрсөлдөх чадвартай, гадаадын хөрөнгө оруулагч нарын сонирхлыг идэвхитэй татаж буй зарим салбарт гадаадын хөрөнгө оруулалтыг шалгаруулан оруулдаг зарчмыг хэрэгжүүлэх юм. Ийм зарчим хэрэгжүүлэх нь уул уурхайн салбарт тулгуурлан хөгжих эрчимтэй хөгжлийн гараанд тулж ирээд байгаа үед улам чухал ач холбогдолтой болж байна. Гадаадын хөрөнгө оруулалтыг уул уурхайн салбарт татах орчин сайжирсаар байгаа бөгөөд олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын Олон улсын зөвлөл Монгол Улсыг газрын тос, байгалийн хий, уул уурхайн үйлдвэрлэлийн салбарт ил тод байдлыг хангасан орноор хүлээн зөвшөөрсөн тухай 2010 оны 10 дугаар сард зарласан болно.

III. Монгол Улсын эдийн засгийн хөгжлийн огцом өсөлт

Монгол Улс эрчимтэй хөгжлийн гарааны эхэнд тулж ирээд байна. Олон улсын валютын сангаас Монгол Улсын 5 тэрбум ам.доллар

хүрэхгүй байгаа одоогийн ДНБ 5 жилийн дотор 2 дахин өсөх бөгөөд ДНБ-ий өсөлт 2013-2016 онд жилд дундажаар 20% өсч ДНБ-ий хэмжээ 2020 онд 2 дахин өсөх аж. Ингэснээр нэг хүнд оногдох ДНБ 10 жилийн дотор 1916 ам.доллараас 7000 ам.долларт хүрэх аж. Харин Үндэсний эдийн засгийн өсөлт прогнозын тооцоогоор манай улсын ДНБ 2010 оныхтой харьцуулахад 2015 онд 2,8 дахин, 2021 онд 7,6 дахин өсөх аж (Лувсандорж П., 2011).

Эдийн засгийн огцом өсөлт нь уул уурхайн олборлолт хийх, бүтээгдэхүүний боловсруулалтын үйлдвэрлэл (“Оюу толгойн төсөл” зэсийн баяжмалын үйлдвэр хоногт 100 мянга, жилд 35 сая тонн хүдэр боловсруулна. Цаашид өдөрт 150 мянга, жилд 56 сая тонн хүдэр боловсруулах чадалтай. “Таван толгой” төсөл жилд 20 сая тонн нүүрс олборлож, 15 сая тонн баяжуулсан нүүрс үйлдвэрлэнэ. “Зэс хайлах үйлдвэр” төсөл жилд 70 мянган тонн катодын зэс үйлдвэрлэнэ. “Хар металлургийн цогцолбор” жилд 2 сая ган хайлж, төмөр замын рельс, хуудас төмөр, том оврын металл хийцүүдийг үйлдвэрлэнэ. “Кокс химийн үйлдвэр” төсөл коксын үйлдвэрээс ялгарах шатдаг хий, битум, бусад химийн түүхий эдийг боловсруулна. “Газрын тос боловсруулах үйлдвэр” дотоодын түүхий эдэд тулгуурласан, технологи нь олон улсын стандартад нийцсэн байна. “Нүүрс химийн үйлдвэр” төсөл нүүрсний орд дээр химийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх цогцолбор.) бий болгох, дэд бүтцийн томоохон бүтээн байгуулалтын зэрэг үйл ажиллагааны үр дүнд бий болох бөгөөд үүнийг түүхий эдэд түшиглэсэн эдийн засгаас боловсруулах үйлдвэрлэлд түшиглэсэн эдийн засагт шилжих анхны алхмууд гэж үзэж болно. Ингэснээр үндэсний эдийн засгийн салбарын бүтцэд аж үйлдвэрийн эзлэх хувь хэмжээ нэмэгдэх юм. 2010 онд аж үйлдвэр 46 хувь эзэлж байсан бол 2015 онд 58, 2021 онд 57 хувь болж тус тус өснө. Хөдөө аж ахуй 2010 онд 14 хувь байсан бол 2015 онд 11 хувь, 2011 онд 8 хувь болж тус тус буурна. Үйлчилгээний салбар 2010 онд 40 хувь байсан бол 2015 онд 31 хувь, 2021 онд 35 хувь болж өөрчлөгдөнө (Лувсандорж П, 2011). Харин манай үйлчилгээний салбарын хувь хэмжээ урт хугацаанд уул уурхайн үйлдвэржилтийг дагасан үйлчилгээ өсдөг онолоор өсч болох талтай.

Оюу толгойн зэс алтны, Таван толгойн нүүрсний олборлолтыг эхлүүлж, Сайншандын аж үйлдвэрийн парк болон бусад томоохон үйлдвэрүүд ашиглалтад орсоноор дунд хугацаанд гадаад худалдааны үзүүлэлтүүд өсч 2013 онд 1,8 тэрбум ам.доллар давсан цэвэр экспорттой болохоор байна (ҮХШХ,2010а).

Эдгээр бүтээн байгуулалтад ихээхэн хэмжээний хөрөнгө оруулалт шаардлагатай бөгөөд олон улсын шинжээч, судлаачид Монгол Улсын эдийн засаг 40 орчим тэрбум ам.долларын хөрөнгө оруулалтыг ойрын жилүүдэд шингээх чадавхтай байгааг тооцоолоод байгаа аж.

Шаардагдах нийт хөрөнгө оруулалтын дотоодын эх үүсвэр, гадаадаас авах зээлийн хэмжээ (ДНБ-ий тодорхой хувиас хэтрэхгүй байх) хязгаарлагдмал учир гадаадын хөрөнгө оруулалт голлох үүрэг гүйцэтгэнэ.

Renaissance Capital судалгаа хийж, Оюу Толгойн хөрөнгө оруулалтын гэрээнд гарын үсэг зурснаар гадаадын хөрөнгө оруулалтын хэмжээ огцом өсч, 2012 оноос Монгол Улсын эдийн засгийн өсөлтийн хурд өндөр өсөлттэй бусад орнууд (Гана, Туркменистан, Хятад, Энэтхэг)-ынхаас илүү болохыг харуулсан (Renaissance Capital).

Хүснэгт 1-д Эдийн засгийн өндөр өсөлттэй 5 улсыг, 2004-2008 онуудын ДНБ-ний өсөлтийн өссөн хувь, үйлдвэрийн гол салбарын хамт үзүүлэв.

Хүснэгт 1-д Эдийн засгийн өндөр өсөлттэй 5 улс


Top 5 fastest growing economies, 2004-2008

Country	2004-2008, cumulative	
	GDP growth	Main inudstry
Azerbaijan	159.5	Oil
Angola	116.4	Oil
Equatorial Guinea	106.1	Metals
Qatar	94.8	Gas
Turkmenistan	78.1	Gas

Эх сурвалж: Renaissance Capital

Эдгээр орнууд газрын тос, байгалийн хий, металл олборлож эдийн засгийн өсөлт нь жилд дундажаар 15,6-31,9% -д хүрчээ.

Зураг . Зарим орнуудын хөгжлийн хурд, 2010 оныг 100% гэж авчээ.



Эх сурвалж: Renaissance Capital

Хүснэгт 2. Өсөлтийн өндөр хурдтай, байгалийн баялагт дулдуйдсан орнуудын (дэлхийн 182 улсын), орлогын тэгш бус байдал (дэлхийн 140 улсын)-ын харьцуулсан үзүүлэлт

Characteristics of fast growth, resource economies, ranking out of 182; income inequality out of 140

Country	Main inustry	Transparency International ranking	Ease of doing business	Income inequality
Azerbaijan	Oil	143	38	53
Angola	Oil	162	169	138
Equatorial Guinea	Metals	168	170	n/a
Qatar	Gas	22	39	83
Turkmenistan	Gas	168	n/a	80
Mongolia	Metals	120	60	33
Canada	Oil and gas	8	10	24
Norway	Gas	11	8	4

Эх сурвалж: Renaissance Capital

Хүснэгт 2-д өсөлтийн өндөр хурдтай, байгалийн баялагт дулдуйдсан дээрх улсуудын ил тод байдлын, бизнес эрхлэх орчин, орлогын тэгш бус байдлын зэрэг үзүүлэлтийг харьцуулсан байна. Хүснэгтээс байгалийн баялаг ашиглан хөгжиж буй Ангол улсын ил тод байдал, бизнес эрхлэх орчин муу, хүн амын орлогын ялгаа их байгааг харж болно. Ил тод байдлын үзүүлэлтээр 22-д жагсаж, бизнес эрхлэх орчны үзүүлэлтээр манайхаас дээгүүр байгаа Катарын хүн амын орлогын түвшний ялгаа дундаж үзүүлэлттэй байхад байгалийн баялагаа ашиглаж хөгжсөн Канад, Норвегийн ил тод байдал, бизнес эрхлэх таатай орчин, хүн амын орлогын ойролцоо түвшин зэрэг үзүүлэлтүүд анхаарал татаж байгаа бөгөөд бид тэдгээрт ойртох зорилт тавих нь зүйтэй болов уу.

Энэ бүгдээс хөгжлийн өндөр өсөлтийг хангахын тулд гадаадын хөрөнгө оруулалтыг татах эрх зүйн орчин, түүнийг шингээх чадавхийг сайжруулах, нөгөөтэйгүүр уул уурхайн давамгайлсан хөгжлөөс гарч болох эрсдэлийг багасгахын тулд төрийн оролцоотой зохицуулалт хийж байх шаардлагатай нь харагдаж байна.

IV. Гадаадын хөрөнгө оруулалт шингээх чадавхи

Манай орны эдийн засгийн өсөлтийн өндөр хурдыг хангахад гадаадын хөрөнгө оруулалт шингээх чадавхийг сайжруулах учиртай.

Судлаачдын (Xialan Fu ба Nguen H., etc) үзэж буйгаар гадаадын хөрөнгө оруулалтыг шингээх чадавхи гэдэгт тухайн орны аж ахуйн нэгж,

компаниудын гадаадын хөрөнгө оруулалтыг шингээх чадавхи, хүний нөөцийн чадавхи, санхүүгийн системийн чадавхи, дэд бүтцийн хөгжил, технологи болон судалгаа шинжилгээний чадавхи, гадаадын хөрөнгө оруулалтын эрх зүй, хэрэгжилтийг хангах орчин нөхцөл зэргийг ойлгох бөгөөд эдгээр нь хэдий чинээ сайн хөгжсөн байна, төдий чинээгээр гадаадын хөрөнгө оруулалтын үр өгөөж өндөр байдаг аж.

Монгол Улсын зээлжих зэрэглэлд даруухан ахиц (“Фитч” компанийн зэрэглэл тогтоох зөвлөлөөс Монгол Улсын зээлжих зэрэглэлийг урт хугацаанд В+ гэж нэг зэрэглэл ахиулж, хэтийн төлвийг “тогтвортой” хэвээр үлдээсэн байхад “Стандарт энд Пүүрс” манай улсын зээлжих зэрэглэлийг урт хугацаанд “ВВ-”, богино хугацаанд “В” хэмээн бататган тогтоож, хэтийн төлвийг “тогтвортой” хэвээр үлдээжээ) гарч байгаа нөхцөлд Монголын Энержи ресоурзис, Соулгоби сендз, Хүннү коал, Занаду майнз зэрэг компани олон улсын хөрөнгийн зах зээл (Гонконг, Австрали)-д хувьцаагаа амжилттай гарган арилжаалж багагүй хэмжээний (нийт 1,6 тэрбум ам.доллар) хөрөнгө босгосон явдал нь манай зарим компаниудын гадаадын хөрөнгө оруулалт шингээх чадавхи харьцангуй сайн байгааг харуулав.

Уул уурхайн хөрөнгө оруулалтыг дагаж бий болох үйлдвэрлэл, үйлчилгээний үндэсний олон компаниуд өсөн торниж байгааг тэтгэн хөгжүүлж олшруулах, компанийн засаглалыг улам боловсронгуй болгох шаардлагатай байгаа билээ. Монголын үндэсний компаниудын засаглалыг дээшлүүлэхэд МҮХАҮТ, Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбоо, саяхан байгуулагдсан хэрэгжүүлэгч агентлаг – Мэргэжлийн боловсрол, сургалтын газрын үйл ажиллагаа чухал юм.

Хүн ам цөөнтэй манай орны хувьд мэргэжилтэй боловсон хүчин илт дутагдаж байгааг Оюу толгойн төслийн хэрэгжилтийн эхнээс харагдав. Хүчин чадал өндөртэй тоног төхөөрөмж, техник хэрэгслэл ашигладаг орчин үеийн уул уурхайн салбар ажлын байр олноор бий болгоод байдаггүй онцлогтой. Дунд хугацаанд уул уурхайн олборлох болон боловсруулах үйлдвэрийн ажиллах хүчний нэмэлт хэрэгцээ 2010-2015 онд нийтдээ 21 мянга гаруй, үүнээс 3 мянга гаруй нь инженер техникийн ажилтан, үлдэх нь мэргэжилтэй ажилчид байх тооцоо хийсэн (ҮХШХ, 2010б) байдаг. Харин уул уурхай, түүнийг дагасан дэд бүтэц, аж үйлдвэрийн цогцолбор барих бүтээн байгуулалтын ажилд ажиллах хүчний хэрэгцээ нилээд гарна. Ийм ажилд гол төлөв эрэгтэй хүн шаардлагатай бөгөөд бүтээн байгуулалтын ажил дууссаны дараа энэ хүмүүсийн ихэнх нь ажилгүй болох эрсдэлтэй тул эдгээр хүмүүст зориулж ажлын байр бий болгох, дахин мэргэшүүлэх шаардлага гарна. Уул уурхайн салбарт ихэнхдээ эрэгтэйчүүд ажилладаг. Тэхлээр эмэгтэй хүн ажиллах ажлын байр, үйлдвэрлэл бий болгох хэрэгтэй.

Дэд бүтэц, боловсруулах үйлдвэрлэлийг өргөжүүлэн хөгжүүлэх эдгээр төслүүдийг санхүүжүүлэх хөрөнгө босгох арга замыг бид дэлхийн санхүүгийн зах зээлээс эрэлхийлж байгаа бөгөөд Монголын хөрөнгийн биржийг олон улсын стандартад нийцүүлэн өөрчлөх ажил явагдаж байна. Санхүүгийн зах зээлийг хөгжүүлэх эдгээр санаачлагууд нь гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдад Монголын хөрөнгийн зах зээлд нэвтрэх, гадаадын хөрөнгө оруулагч нарт Төрийн өмчит компаниудын хувьцаа, Засгийн газрын бонд эзэмших боломж олгож, эрсдлийг бууруулах зэргээр Монголын хөрөнгийн зах зээлийг олон улсад нээх явдал юм.

Банкны зээлийн хүү харьцангуй өндөр байгаа нь хөрөнгө оруулалтыг богино хугацаанд нөхөх салбар, тухайлбал, уул уурхайн олборлолтын салбарт чиглүүлж, боловсруулах үйлдвэрлэлийн салбарын хөгжилд сөргөөр нөлөөлж байна. ЖДҮ-ийг дэмжих эхний оролдлого байгаа боловч цаашид зээлийн хүүг бууруулах, зээлийн хугацааг уртасгах шаардлага байсаар байгаа болно.

Хөрөнгө оруулалт, эдийн засгийн гэнэтийн өсөлтөөс улбаалан гарч болох сөрөг үр дагавараас урьдчилан сэргийлэх зорилгоор 2010 онд батлагдсан Төсвийн тогтвортой байдлын тухай хууль 2013 оноос эхлэн хэрэгжих бөгөөд энэ хуулийн дагуу улс орны томоохон хөгжлийн төслүүдийг санхүүжүүлэх зориулалттай Хөгжлийн банк байгуулагдахаар болов. Тус банкинд улсын төсвөөс оруулах анхны хөрөнгийн хэмжээг тогтоосон бөгөөд эхний ээлжинд уул уурхайн бүтээгдэхүүн тээвэрлэх төмөр зам тавих, аж үйлдвэрийн цогцолбор барих зэрэг төслүүдийг санхүүжүүлэх юм.

Гадаадын хөрөнгө оруулалт шингээх чадавхид дэд бүтцийн хөгжлийн, ялангуяа зам тээврийн асуудал чухал ач холбогдолтой тул төрөөс төмөр замын талаар баримтлах бодлого, Концессын тухай хуулийг УИХ батласан нь улсын болон орон нутгийн чанартай төслүүдийг хувийн хэвшлийнхнээр гүйцэтгүүлэх эрх зүйн орчныг бий болгож, улмаар зарим яамд холбогдох тендерийг зарлаад байна. Зарим аймаг, орон нутгийн захиргаа энэ чиглэлд идэвхитэй ажиллаж байна. тухайлбал, саяхан Сайншандад болсон “Хөгжлийн бүс–Дорноговь” гадаадын хөрөнгө оруулагчдын чуулга уулзалт, төмөр замын шав тавих ёслол зэргийг дурдаж болох юм. Засгийн газрын эхний ээлжинд хэрэгжүүлэх 26 төслөөс 11 нь Дорноговь аймгийн нутаг дэвсгэрт хэрэгжихээр байгаа.

Хэдийгээр манай нийт хүн ам бичиг үсэгт тайлагдсан, гар утас, компьютер хэрэглэгчдийн эзлэх хувь хэмжээ харьцангуй өндөр байгаа боловч шинжлэх ухаан, технологийн чиглэлээр суралцаж байгаа оюутны тоо цөөн, экспортын өрсөлдөх бүтээгдэхүүний нэр төрөл нэмэгдэхгүй байгаа, технологийн доод түвшний боловсруулалттай бүтээгдэхүүний нийт экспортод эзлэх хувь хэмжээ өндөр байна. Өөрөөр хэлбэл илүү нэмүү өртөг бий болгох гадаадын хөрөнгө оруулалт

шингээх чадавхи доогуур байна гэсэн үг. Манай орны технологийн болон судалгаа шинжилгээний чадавхийг дээшлүүлж чадвал гадаадын хөрөнгө оруулалтын үр өгөөжийг нэмэгдүүлэх боломжтой. “Төрөөс өндөр технологийн аж үйлдвэрийн талаар баримтлах бодлого”-ыг 2010 оны 6 сард УИХ-аас баталж өндөр технологийн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж байгаа аж ахуйн нэгжид татварын хөнгөлөлт үзүүлэх, хөрөнгө оруулалтыг татвараас чөлөөлөх, зээлийн баталгаа олгох эрх зүйн үндсийг бүрдүүлэх заалтууд тусгасан байна.

Хөрөнгө оруулагчид Монгол Улсын гадаадын хөрөнгө оруулалтын орчинг боломжийн хэмээн үзэж үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд судлаачид Гадаадын хөрөнгө оруулалтын тухай Монгол Улсын хууль, Эрдэс баялагийн салбар дахь гадаадын хөрөнгө оруулалтын эрх зүйн орчныг хууль тогтоомжийн түвшинд бүрэлдсэн хэмээн үзэж байна (Мэндсайхан Т, 2011).

Энэ бүгдээс, хэдийгээр холбогдох хууль тогтоомжийг боловсронгуй болгох үйл ажиллагаа явагдаж байгаа боловч Монгол Улсын гадаадын хөрөнгө оруулалт шингээх чадавхи сайжирч байна гэж дүгнэж болохоор байна.

Ү. Гадаадын хөрөнгө оруулалтын зохицуулалт

Уул уурхайн салбарт давамгайлан орох хөрөнгө оруулалт нь эдийн засгийн бүтцэд өөрчлөлт оруулж, уул уурхайн их хэмжээний экспортын орлогоос улбаалан үндэсний мөнгөн тэмдэгтийн ханш чангарах, инфляци өсөх зэрэг үзэгдэл гарч болох нь ажиглагдаж эхлэв. Тухайлбал, 2010 оны эцэст монгол төгрөгийн ханш оны эхнийхээс 15 хувиар чангарч үзүүлэлт сайтай дэлхийн мөнгөн тэмдэгтийн 2 дугаарт, австрали долларын дараа бичигдэж, инфляци 14,3 хувиар өсөв. Эдийн засгийн өндөр өсөлтийг хангах уул уурхайн олборлох салбарын хөрөнгө оруулалт урьдынхтай харьцуулахад олон дахин нэмэгдэх нь эдийн засагт сөргөөр нөлөөлөх зарим эрсдэлийг дагуулж болзошгүй тул эдгээр эрсдэлийг тодорхойлох, удирдах, хариу арга хэмжээ авах нь тулгамдсан асуудал болоод байна.

Монгол Улсын Их Хурлын 2010 оны 48 тоот тогтоолоор Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал (ҮАБҮБ)-ын, 2011 оны 10 тоот тогтоолоор Гадаад бодлогын үзэл баримтлал (ГБҮБ)-ын шинэчилсэн найруулга тус тус батлагдав.

ҮАБҮБ-д үндэсний хөрөнгө оруулагчдын улс орны эдийн засгийн хөгжилд шийдвэрлэх үүргийг тодорхойлноос гадна “...стратегийн ач холбогдолтой салбарт хөрш орнууд, өндөр хөгжилтэй бусад орноос оруулах хөрөнгө оруулалтын хэмжээг тэнцвэртэй байлгах бодлого баримтлах, гадаадын хөрөнгө оруулалтыг өрсөлдөх чадвар, санхүү, менежментийн үр өгөөжийг дээшлүүлэх, шинэ технологи нэвтрүүлэх,

урт хугацааны хөгжлийн үндсийг тавих чухал хөшүүрэг, арга хэрэгсэл болгоно гэсэн тодорхой заалтууд орсон (ТМ,2010).

ГБҮБ-д “... эдийн засгийн аюулгүй байдлыг бүх талаар хангахыг эрмэлзэж, аль нэг улсаас хэт хараат байдалд орохоос сэрэмжилнэ” гээд эдийн засгийн салбаруудад тэргүүний технологи, менежмент нэвтрүүлж, ажил, үйлчилгээ, бүтээгдэхүүний чанар, стандартыг олон улсын жишиг, түвшинд ойртуулан нийцүүлэх замаар өрсөлдөх чадварыг нь дээшлүүлэх, экспортын хэмжээг өсгөхийг дэмжих; уул уурхай, хөдөө аж ахуйн түүхий эдийг бүрэн боловсруулж, нэмүү өртөг шингэсэн эцсийн бүтээгдэхүүн гаргах, импорт орлох бүтээгдэхүүн үйлдвэрлэх, ажлын байр нэмэгдүүлэх, түүнчлэн мэдлэгт суурилсан үйлдвэрлэл хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх болон бусад салбарт баримтлах, ... эрдэс болон хөдөө аж ахуйн түүхий эдийг гүнзгий боловсруулах, дэвшилтэт арга технологийг сонгон нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлэх, инновац нэвтрүүлэх, цөмийн технологийг энхийн зорилгоор ашиглах чиглэлээр хамтын ажиллагааг идэвхжүүлэх, сэргээгдэх эрчим хүч ашиглах төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх, мэдээллийн технологийн салбарт гадаадын хөрөнгө оруулалт, орчин үеийн ололтыг нэвтрүүлэх, шинжлэх ухаан-технологийн үндэсний мэдээллийн сүлжээг өргөтгөн хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зэргийг тодорхой заасан байна (ТМ,2011).

Ийнхүү ҮАБҮБ, ГБҮБ-аар Монгол Улсын гадаадын хөрөнгө оруулалтын бодлогыг хэрэгжүүлэх тодорхой чиг үүргийг холбогдох төрийн байгууллагуудад өгөв.

ҮІ. Дүгнэлт, санал

Монгол Улсын эрчимтэй хөгжилд ихээхэн хэмжээний хөрөнгө оруулалт шаардагдах бөгөөд үүнийг хэрэгжүүлэхэд гадаадын хөрөнгө оруулалтыг татах, үр ашгийг нь дээшлүүлэхийн тулд манай орны хөрөнгө оруулалт шингээх чадавхийг дээшлүүлэх явдал чухал ач холбогдолтой байна.

Дунд болон урт хугацаанд уул уурхайд оруулсан хөрөнгө оруулалтаас олох орлогыг бусад салбарыг хөгжүүлэх, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний боловсруулах үйлдвэрлэлийн өрсөлдөх чадварыг сайжруулах, хүн амын эрүүл мэнд, боловсрол, дэд бүтцийн хөгжилд зарцуулах, цаашилбал, гадаадад байршуулах зэрэг асуудлыг нарийвчлан судалж төрийн зохицуулалттайгаар хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Эшлэл, зүүлт

- ◆ Ганзориг Б., 2008, “Гадаадын хөрөнгө оруулалтын төрийн зохицуулалт”, Ph.D зэрэг горилон бичсэн нэгэн сэдэвт судалгааны бүтээл, Улаанбаатар хот.
- ◆ ГЕГ, 2010, Гадаад худалдааны барааны статистик мэдээлэл, 2010 оны 12 сар, Улаанбаатар хот.
- ◆ ГХОГ, 2011, Гадаадын хөрөнгө оруулалтын газрын статистик мэдээлэл, 2010 он, Улаанбаатар хот.
- ◆ Лувсандорж П., 2011, *Монголын төр онцлог үүргээ гүйцэтгэж эхлэв*, Өдрийн сонин, 2011.03.22-ны 075(3777) дугаар, 17-р нүүр, Улаанбаатар.
- ◆ МҮХАТ, 2010, Монгол Улсын гадаад худалдааны өнөөгийн байддал, ХЕС-ийг ашиглан зах зээлд хөнгөлөлттэй нэвтрэх боломж, 2010 оны 9 сарын 13, Улаанбаатар.
- ◆ Мэндсайхан Т., 2011, *Эрдэс баялгийн салбар дахь Гадаадын хөрөнгө оруулалтын эрх зүйн орчин*, “Эрдэс баялгийн салбар дахь Гадаадын хөрөнгө оруулалтын эрх зүйн орчин” сэдэвт эрдэм шинжилгээний бага хурал, 2011 оны 4 сарын 18, Хууль зүйн үндэсний хүрээлэн, Улаанбаатар хот.
- ◆ НДЕГ, 2011, Нийгмийн даатгалын ерөнхий газраас авсан статистик мэдээлэл, 2011, Улаанбаатар
- ◆ ҮХШХ 2010 а, *Инноваци ба хөгжил*, Б.Ганбат, Бодлого боловсруулагч, шийдвэр гаргачдад зориулсан семинар, 2010.10.22, Улаанбаатар.
- ◆ ҮХШХ 2010 б, *Эдийн засгийн өсөлт, бодит салбарын хөгжлийн хандлага*, Ч.Батхүрэл, 2011.09.21., Иргэний танхим, Төрийн ордон, Улаанбаатар
- ◆ ТЕГ, 2010, Татварын Ерөнхий газраас авсан статистик мэдээлэл, 2010, Улаанбаатар.
- ◆ Төрийн мэдээлэл (ТМ), 2010, Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, ТМ сэтгүүлийн 48 дугаар, Улаанбаатар, Монгол Улс.
- ◆ Төрийн мэдээлэл (ТМ), 2011, Гадаад бодлогын үзэл баримтлал, ТМ сэтгүүлийн дугаар, 2011, Улаанбаатар, Монгол Улс.
- ◆ OECD, 2006, *Policy Framework for Investment*, OECD, 2006, Paris, France <http://www.oecd.org/dataoecd/1/31/36671400.pdf>
- ◆ Nguen H., etc., 2008, Foreign Direct Investment Absorptive Capacity Theory, http://globelics2009dakar.merit.unu.edu/papers/1238510767_HN.pdf
- ◆ Renaissance Capital, 2010, *Mongolia – Handling Explosive Growth* by Roland Nash, head of Renaissance Capital, 2nd Annual Mongolian Capital Markets Conference, Chinggis Khaan Hotel, Ulaanbaatar, 29 September, 2010
- ◆ Xialan Fu, 2008, Foreign Direct Investment, Absorptive Capacity and Regional Innovation Capabilities: Evidence from China, OECD Global Forum on International Investment, 27-28 March 2008.